



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/87

Мөрөн сум

Аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Биеийн тамир спортын улсын хорооны даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/26 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Монгол Улсад Ковид-19 цар тахлын улмаас үүсч буй сорилт бэрхшээлийг даван туулахад хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх эрүүл амьдрах, зөв дадал хэвшилд сургах дасгал хөдөлгөөнөөр дархлааг дэмжих зорилготой Монгол улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аяны хүрээнд "Илүүдэл жингүй-Эрүүл иргэнтэй Хөвсгөл" идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих аяныг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, аяны удирдамжийг хоёрдугаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Илүүдэл жингүй-Эрүүл иргэнтэй Хөвсгөл" аяныг удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Ч.Ганбаатар)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 03
дугаар сарын 21-ний өдрийн А/87
дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

**“ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРҮҮЛ ИРГЭНТЭЙ ХӨВСГӨЛ”
АЯНЫ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Ч.Ганбаатар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч)

Гишүүд:

Г.Нарангэрэл (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Баярсайхан (Аймгийн Биеийн тамир спортын газрын дарга)

Ц.Ганзориг (Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

М.Үүрийнбаяр (Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга)

Б.Батбаяр (Мөрөн сумын Засаг дарга)

Б. Банзрагч (Аймгийн Хөгжимт драмын театрын дарга)

Т.Хөвсгөл (Аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн)

Б.Батаа (Аймгийн Биеийн тамир спортын газрын арга зүйч)

Г.Баярдэлгэр (Аймгийн Биеийн тамир спортын газрын арга зүйч)

О.Баатармөнх (Аймгийн Биеийн тамир спортын газрын дасгалжуулагч)

Э.Мөнхнасан (Аймгийн Биеийн тамир спортын газрын дасгалжуулагч)

Б.Төмөрчөдөр (Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын
мэргэжилтэн)

Д.Оюунсайхан (Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн)

М.Мандахцэцэг (Аймгийн Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн багш)

Г.Төмөрбаатар (Аймгийн Ахмадын хорооны дарга -тохиролцсоноор)

М.Наранпүрэв (“Наран” Фитнесс төвийн тэргүүн -тохиролцсоноор)

Н.Оюунчимэг (Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
байгууллагуудын үндэсний холбооны Хөвсгөл аймаг дахь
салбар зөвлөл- тохиролцсоноор)

Б.Ганзориг (Аймгийн бүжгийн холбооны тэргүүн -тохиролцсоноор)

Ц.Отгонцэцэг (Аялгуу бүжгийн холбоо тохиролцсоноор)

Нарийн бичгийн дарга:

Б.Ганчимэг (Аймгийн Биеийн тамир, спортын газрын ахлах арга зүйч)

Аймгийн Засаг даргын 2022 оны 03
дугаар сарын 21-ний өдрийн А/87
дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

**“ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ -ЭРҮҮЛ ИРГЭНТЭЙ
ХӨВСГӨЛ” АЯНЫ УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1,66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1 дэх заалт, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Биеийн тамир спортын Улсын хорооны даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/26 дугаар тушаал, “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аян, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1 дэх заалтын хэрэгжилт

Хоёр. Зорилго

Хүн амыг хөдөлгөөний дутагдал, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, бие бялдраа чийрэгжүүлж биеийн дархлааг дэмжих, иргэдийг эрүүл амьдрах хэв маягт төлөвшүүлэх, дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж илүүдэл жингүй эртэч, идэвхтэй иргэнийг бий болгоход аяны зорилго оршино.

Гурав. Зорилт

“Илүүдэл жингүй- Эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяны арга хэмжээг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ.

3.1. Аяны хүрээнд Төрийн байгууллагуудын дунд “Илүүдэл жингүй -Албан хаагчид” болзолт уралдааныг зарлаж хэрэгжүүлэх / Бүх төрийн байгууллагууд хамрагдана/

3.2 Нийтийн биеийн тамираар хичээллэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр байгууллага, сум, аж ахуйн нэгжүүд, биеийн тамирын багш, арга зүйчид, спортын холбоо, клубууд аяны хүрээнд тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх

3.3 Нийтийг хамарсан идэвхтэй дасгал хөдөлгөөн / өглөөний дасгал, алхах, гүйх, дугуй унах,/-ийг дэмжсэн олон талт арга хэмжээг зохион байгуулах, тогтмол дасгал хөдөлгөөн хийгдэх заал, талбай, барилга байгууламж нийтийн эзэмшлийн газар, цэцэрлэгт хүрээлэн,гадаа талбайг сурталчлан таниулах

3.4 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, холбоо, клуб, фитнес төвүүдийн хамтын ажиллагааг уялдуулах

Дөрөв. Удирдлага зохион байгуулалт

4.1 Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газраас “Илүүдэл жингүй-эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяныг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж зохион байгуулна.

4.2 Аяныг хэрэгжүүлэх ерөнхий чиг үүргийг сумын удирдлагууд, Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш нар, биеийн тамирын орон тооны болон орон тооны бус арга зүйчид хариуцна.

4.3 Хамтран зохион байгуулах байгууллагаар аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар, Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар, Хөгжимт драмын театр, Аймгийн ахмадын хороо, Аялгуу бүжгийн холбоо, Наран фитнесс төв, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны Хөвсгөл аймгийн салбар зөвлөл, Алхалт, Гүйлт, Дугуйн холбоо, Клубүүд.

Тав. Хамрах хүрээ

5.1 Арга хэмжээнд аймгийн Төрийн болон Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хамруулна. 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр хүртэл зохион байгуулагдана.

Аяны хүрээнд гүйцэтгэх ажлууд:

Зургаа. Аймгийн Засаг даргын Тамгын газар дараах ажлыг гүйцэтгэнэ.

6.1 “Илүүдэл жингүй- Эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяныг бүтэн жилийн турш зохион байгуулахад Төрийн болон Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалан оролцуулж, дараах байгууллагуудын хэрэгжүүлж байгаа ажилд хяналт тавих

6.2. Хэвлэл мэдээллийн байгууллагуудыг тогтмол ажиллуулах

6.3 Аяны хүрээнд зохион байгуулж байгаа идэвхтэй хөдөлгөөн, өглөөний дасгал, арга хэмжээнд Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадаараа манлайлж оролцох

6.4 Аянтай холбоотой төсвийг тодорхой хэмжээнд санхүүжүүлэх

6.5. Аймгийн хэмжээнд Сумдын Засаг дарга, Ерөнхий боловсролын сургуулийн захирал, Биеийн тамирын багш, Орон тооны болон орон тооны бус арга зүйч, Эрүүл мэндийн төвийн арга зүйчид, Ахмадын чийрэгжүүлэх төвийн ахлагч, спортын холбоодын дунд “Нийтийн биеийн тамирыг эрчимжүүлэх” зөвлөгөөнийг Биеийн тамир спортын газар, Эрүүл эрүүл мэндийн газар, Боловсрол шинжлэх ухааны газартай хамтран зохион байгуулах

Долоо. Биеийн тамир спортын газар дараах ажлыг гүйцэтгэнэ.

7.1 Аймгийн хэмжээнд өглөөний дасгалыг нэгдсэн журмаар ажлын өдрүүдэд 06:30-07:30 цагт Биеийн тамир спортын газрын “А” заал, гимнастикийн зааланд тус тус дасгалуудыг хийж зохион байгуулна.

7.2 Албан байгууллага, аж ахуйн нэгж, сум, хороодын иргэдийн дунд биеийн тамирын өдөрлөгүүдийг зохион байгуулахад мэргэжил арга зүйгээр хангах

7.3 Илүүдэл жинтэй таргалалтанд нөлөөлж байгаа хүний буруу зан үйл, ажиллах хэв маягийг өөрчлөх, идэвхтэй хөдөлгөөн эрүүл зөв хооллолт, дасгал хөдөлгөөний зөвлөмжийг тогтмол өгөх, сурталчлах

7.4 Иргэн, гэр бүл, байгууллага, салбарын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөний жор, зөвлөмжүүдийг бэлтгэж хүргэх

7.5 Өдөр бүр алхах, гүйх, дугуй унах, дасгал хөдөлгөөн хийх аюулгүй хүртээмжтэй дэд бүтэц, барилга байгууламж, нийтийн эзэмшлийн газар, цэцэрлэгт хүрээлэн, орчин бий болгохыг уриалах

7.6 Идэвхтэй хөдөлгөөнийг дэмжсэн олон талт арга хэмжээг Төрийн болон Төрийн бус байгууллагатай аж ахуйн нэгж, хамтран зохион байгуулж, Мөрөн суманд “Чингүнжавын талбай”, “Биеийн тамир спортын газар”-ын гадаа талбай, “Соёмбо цогцолбор”-ын талбайд өглөөний дасгалыг хийж хэвшүүлэн эртэч идэвхтэй иргэнийг бий болгох, буруу зан үйл, амьдрах, ажиллах хэв маягийг өөрчлөх, дасгал хөдөлгөөнөөр ухуулга нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлэх

7.7 Өвлийн улиралд мини мөсөн гулгуурийн талбайг тодорхой цэгт байгуулж ажиллуулах

7.8 “Илүүдэл жингүй- Эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяныг сурталчлан таниулах, байгууллага, иргэдийг дасгал хөдөлгөөнд идэвхтэй хамруулж, нийтийн биеийн тамираар хичээлэгсэдийн тоог нэмэгдүүлэх

7.9 “Илүүдэл жингүй- Эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяныг хэвлэл мэдээллээр сурталчлан ажиллах

7.10 “Илүүдэл жингүй- Эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяны хүрээнд Төрийн болон Төрийн бус байгууллага, сумдын орон тооны болон орон тооны бус арга зүйчдийн дунд групп чат үүсгэж мэдээ тайланг авч ажиллах

7.11 Аяны хүрээнд зохион байгуулж байгаа өглөөний дасгал хөдөлгөөн болон аяны хүрээнд хийгдэж байгаа ажлын явцын дүн мэдээг зураг, бичлэг, тоон үзүүлэлтээр гаргаж нэгтгэн өдөр бүр Биеийн тамир спортын Улсын хороонд, аяны тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэх

7.12 Аяныг удирдамжийн дагуу дүгнэж, үр дүнг тооцох

Найм. Боловсрол шинжлэх ухааны газар дараах ажлуудыг гүйцэтгэнэ.

8.1 “Илүүдэл жингүй- Эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяны хүрээнд зохион байгуулж байгаа идэвхтэй хөдөлгөөнийг дэмжиж Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын албан хаагчдыг уриалан байгууллагаараа дэмжин оролцох

8.2 Ерөнхий боловсролын сургуулиудын спорт заалыг 7 хоног бүрийн 4 дэх өдрийн 19.00 цагаас 22.00 цагт иргэдэд үнэ төлбөргүй үйлчлэх боломжоор хангах

8.3 Аяны хүрээнд зохион байгуулагдаж байгаа өглөөний дасгалыг 6.30-7.30 цагийн хооронд тогтмол хийж хэвших ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах ба иргэдэд сурталчлан дасгал хөдөлгөөнд хамруулах

8.4 Сургууль, Цэцэрлэгийн эмч, биеийн тамирын багш нар багш ажилчдын биеийн жингийн индексийг тодорхойлох ба тухайн сургуулийн спорт зааланд өглөөний дасгал хийж байгаа иргэдийн эрүүл мэндийг хянаж, сургуулийн эмчийг ажилуулах.

8.5 Халдвар хамгаалалтын дэглэмийг баримтлуулж, зөвлөмж зөвлөгөөг тогтмол өгч сургууль, цэцэрлэгүүдийн аяны хүрээнд зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах

8.6 Аяны хүрээнд 06.30-07.30 цагийн хооронд зохион байгуулж байгаа өглөөний дасгалын явцын дүн мэдээг зураг, бичлэг, тоон үзүүлэлтээр гаргаж өдөр бүр 09.00 цагаас өмнө, аяны хүрээнд хийсэн ажлын тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Биеийн тамир спортын газарт өгнө.

Ес. Эрүүл мэндийн газар дараах ажлыг хэрэгжүүлнэ.

9.1 “Илүүдэл жингүй- Эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяны хүрээнд зохион байгуулж байгаа идэвхтэй хөдөлгөөнийг уриалан салбараараа дэмжин ажиллах

9.2 Төрийн байгууллагуудын дунд зохион байгуулах “Илүүдэл жингүй- Албан хаагчид” болзолын удирдамжийг боловсруулан гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх

9.3 Өглөөний дасгалд оролцох байгууллагуудын хуваарь гаргаж оролцуулах

9.4 Иргэдэд зориулсан идэвхтэй хөдөлгөөн, эрүүл зөв хооллолтын чиглэлээр гарын авлага зөвлөмжүүдийг бэлтгэж, мэдээлэл түгээх

9.5 Сумын эрүүл мэндийн төвийн арга зүйчид орон нутагтаа албан хаагчид, иргэдийн биеийн жингийн индексийг тодорхойлох ажлыг зохион байгуулах

9.6. Аяны хүрээнд 06.30-07.30 цагийн хооронд зохион байгуулж байгаа өглөөний дасгалын явцын дүн мэдээг зураг, бичлэг, тоон үзүүлэлтээр гаргаж өдөр бүр 09.00 цагаас өмнө, аяны хүрээнд хийсэн ажлын тайланг сар бүрийн 25-ны дотор Биеийн тамир спортын газарт өгнө.

Арав. Сумдын Засаг даргын Тамгын газар дараах ажлыг хэрэгжүүлнэ.

10.1 “Илүүдэл жингүй- Эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяныг сурталчилж, иргэдийг идэвхтэй хамруулах ажлыг өргөн хүрээнд зохион байгуулж орон нутагтаа ажлын хэсэг байгуулан уриалж оролцох

10.2. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа Ерөнхий боловсролын сургуулийн спорт заал, Соёлын төвийн спорт заал, Фитнесс төв, чийрэгжүүлэлтийн төвүүдийн заалийг 7 хоног бүрийн 4 дэх өдөр 19.00- 22.00 цагийн хооронд иргэдэд үнэ төлбөргүй үйлчлэх боломжоор хангах

10.3. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа спорт заалуудад өдөр бүр өглөөний 06.30-07.30 хооронд өглөөний дасгалыг хийж хэвшүүлэх

10.4. Идэвхтэй хөдөлгөөн, эрүүл зөв хооллотын чиглэлээр гарын авлага зөвлөмжүүдийг бэлтгэж иргэдэд хүргэх

10.6. Биеийн тамирын багш, арга зүйчид иргэдийнхээ биеийн жингийн индексийг тодорхойлох ба сорилын дүн мэдээг нэгтгэж Биеийн тамир, спортыг газарт өгөх

10.7. Ахмадуудыг дасгал хөдөлгөөнд тогтмол хамруулах, чийрэгжүүлэлтийн төвийн ахлагч нарыг эрчимтэй ажиллуулах

10.8. Аянтай холбоотой олон нийтийг хамруулсан өдөрлөг, уралдаан тэмцээн, арга хэмжээг 1-2 удаа зохион байгуулж эрүүл зан үйлд уриалах

10.9. Сум бүр төрийн албан хаагчдын дунд жилийн турш зохион байгуулж байгаа “Илүүдэл жингүй – Албан хаагчид” болзолт уралдаанд идэвхтэй оролцох

10.10. Аяны хүрээнд 06.30-07.30 цагийн хооронд зохион байгуулж байгаа өглөөний дасгалын явцын дүн мэдээг зураг, бичлэг, тоон үзүүлэлтээр өдөр бүр 09.00 цагаас өмнө, аяны хүрээнд хийсэн ажлын тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Биеийн тамир спортын газарт өгнө.

10.12. Аяны нэгдсэн явцын тайланг 2022 оны 12 дугаар сарын 16-ны дотор, эцсийн тайланг 2023 оны 03 дугаар сарын 10-ны дотор аймгийн Биеийн тамир, спортын газар хүргүүлнэ.

Арван нэг. Хөгжимт драмын театрын хэрэгжүүлэх ажил

11.1. “Илүүдэл жингүй- Эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяны хүрээнд зохион байгуулж байгаа идэвхтэй хөдөлгөөнийг дэмжиж байгууллагаараа оролцох

11.2. Аяны хүрээнд зохион байгуулагдаж байгаа өглөөний дасгалыг 6.30-7.30 цагийн хооронд тогтмол хийж хэвших ба ойролцоо хорооллын иргэддээ нийтийг хамарсан бүжгийн алхалт хөдөлгөөнүүдийг зааж, сурталчлан таниулах

11.3 “Илүүдэл жингүй- Эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяны хүрээнд өглөө бүр Чингүнжавын талбайд хийгдэх дасгал, бүжгийн хөдөлгөөнийг хувиарын дагуу ард иргэдэд хүргэж ажиллана.

11.4. Аяны хүрээнд 06.30-07.30 цагийн хооронд зохион байгуулж байгаа өглөөний дасгалын явцын дүн мэдээг зураг, бичлэг, тоон үзүүлэлтээр өдөр бүр 09.00 цагаас өмнө, аяны хүрээнд хийсэн ажлын тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Биеийн тамир спортын газарт өгнө.

Арван хоёр. Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөл дараах ажлуудыг хэрэгжүүлнэ.

12.1. Аяны хүрээнд ажлын хэсэг гарган хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг идэвхтэй хөдөлгөөн, өглөөний дасгалд хамруулж уриалан зохион байгуулах

12.2. Биеийн тамир спортын газраас өгч байгаа заавар зөвлөмжүүдийг иргэддээ хүргэж ажиллах

12.3. Биеийн тамир спортоор хичээллэдэг буюу хичээллэх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонсголын, харааны, оюуны, тулгуур эрхтэний гэж ангилан судалгааг гаргаж хамтран ажиллах

12.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийтийг хамарсан спортын уралдаан тэмцээн, сургалт зөвлөгөөнд хамруулан оролцуулах / оролцуулсан иргэдийн тоон судалгааг өгөх/

12.5 Аяны хүрээнд 06.30-07.30 цагийн хооронд зохион байгуулж байгаа өглөөний дасгал болон бусад арга хэмжээний явцын дүн мэдээг зураг, бичлэг, тоон үзүүлэлтээр өдөр бүрийн 09.00 цагаас өмнө, аяны хүрээнд хийсэн ажлын тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Биеийн тамир спортын газарт өгнө.

Арван гурав. Аймгийн ахмадын хорооны хэрэгжүүлэх ажил

13.1. Аяны хүрээнд “Ахмадын чийрэгжүүлэлтийн төв”-үүдээрээ дамжуулан ахмадууд болон иргэдийг дасгал хөдөлгөөнд хамруулах ажлыг зохион байгуулж ажиллана.

13.2. Ахмадуудыг нийтийг хамарсан спортын уралдаан тэмцээн, сургалт зөвлөгөөнд хамруулан оролцуулах / оролцуулсан иргэдийн тоон судалгааг өгөх/

13.3. Аяны хүрээнд 06.30-07.30 цагийн хооронд зохион байгуулж байгаа өглөөний дасгал буюу бусад арга хэмжээний явцын дүн мэдээг зураг, бичлэг, тоон үзүүлэлтээр өдөр бүр 09.00 цагаас өмнө, аяны хүрээнд хийсэн ажлын тайланг улиралд 1 удаа Биеийн тамир спортын газарт өгнө.

Арван дөрөв. Төрийн болон Төрийн бус байгууллага,
аж ахуйн нэгжүүдийн хэрэгжүүлэх ажил

14.1. “Илүүдэл жингүй- Эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяныг сурталчлаж албан хаагчид, иргэдийг идэвхтэй хамруулах ажлыг өргөн хүрээнд зохион байгуулж байгууллага бүр ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө гаргаж уриалж оролцох

14.2. Байгууллагынхаа ажилтан албан хаагчидыг орон тооны бус арга зүйчидээрээ дамжуулан өглөө бүр 06.30-07.30 хооронд өглөөний дасгалыг хийж хэвшүүлэх

14.3. Байгууллага тус бүр байгууллагын ажилтан албан хаагчдын биеийн жингийн индексийг тодорхойлуулах /үүнд зөвхөн төрийн байгууллагууд хамрагдана/

14.4. Идэвхтэй хөдөлгөөн, эрүүл зөв хооллотын чиглэлээр сургалт, гарын авлага зөвлөмжүүдийг ажилтан, албан хаагчдад хүргэх /зөвлөмжийг Биеийн тамир спортын газар, Эрүүл мэндийн газраас авах/

14.5. Төрийн байгууллагуудын дунд жилийн турш зохион байгуулж байгаа “Илүүдэл жингүй –Албан хаагчид” болзолт уралдаанд идэвхтэй оролцох

14.6. Аяны хүрээнд 06.30-07.30 цагийн хооронд зохион байгуулж байгаа өглөөний дасгалын дүн мэдээг зураг, бичлэг, тоон үзүүлэлтээр гаргаж өдөр бүрийн 09.00 цагаас өмнө, аяны хүрээнд хийсэн ажлын тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Биеийн тамир спортын газарт хүргүүлнэ.

Арван тав. “Наран” фитнесс төв дараах ажлуудыг хэрэгжүүлнэ.

15.1 “Илүүдэл жингүй- Эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяныг сурталчилж, иргэдийн идэвхтэй хамруулах ажлыг өргөн хүрээнд зохион байгуулж ажлын хэсэг байгуулан уриалж оролцох

15.2 Фитнессээр үйлчлүүлж байгаа иргэдийг буюу ойролцоох хорооллын иргэдийг 06.30-07.70 цагт өглөөний дасгалд хамруулах

15.3 Аяны хүрээнд ард иргэдэд гарын авлага зөвлөмж өгөх, аяныг сурталчлан таниулах үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулах

15.4 Аянд оролцсон дасгал хөдөлгөөнөөр идэвхтэй оролцсон иргэдийг дэмжиж шагнаж урамшуулах

15.5 Аяны хүрээнд 06.30-07.30 цагийн хооронд зохион байгуулж байгаа өглөөний дасгалд оролцож байгаа явцын дүн мэдээг зураг, бичлэг, тоон үзүүлэлтээр өдөр бүр 09.00 цагаас өмнө өгөх ба аяны хүрээнд хийсэн ажлын тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Биеийн тамир спортын газарт өгнө.

Арван тав. Санхүүжилт, урамшуулал

15.1. Аяны хүрээнд зохион байгуулагдах үйл ажиллагааны зардлыг тухайн агентлаг, байгууллага, сум, аж ахуйн нэгжүүд өөрсдөө хариуцна.

15.2. Аяныг дүгнэж агентлаг, байгууллага, сум, аж ахуйн нэгж, спортын холбоод, клубуудыг тус бүрт нь байр эзлүүлж урамшуулна.

Аймгийн Засаг даргын 2022 оны 03
дугаар сарын 21-ний өдрийн А/87 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт



**“ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ -ЭРҮҮЛ ИРГЭНТЭЙ ХӨВСГӨЛ”
АЯНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Аяны нэр: “Илүүдэл жингүй- Эрүүл иргэнтэй Хөвсгөл”

Аяны уриа: “Идэвхтэй хөдөлгөөн-Хамтын оролцоо”

Аяны хугацаа: 2022 оны 03 дугаар сарын 21-нээс 2023 оны 03 дугаар сарын 21.

Аяны зорилго: Хүн амыг хөдөлгөөний дутагдал, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, бие бялдраа чийрэгжүүлж биеийн дархлааг дэмжих, иргэдийг эрүүл амьдрах хэв маягт төлөвшүүлэх, дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж илүүдэл жингүй эртэч, идэвхтэй иргэнийг бий болгоход аяны зорилго оршино.

Үйл ажиллагааны төлөвлөгөө:

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Ажлын хэсгийн хариуцах эзэн
Зорилт-1. Аяны хүрээнд төрийн байгууллагуудын дунд “Илүүдэл жингүй -Албан хаагчид” болзолт уралдааныг зарлаж хэрэгжүүлэх /Бүх төрийн байгууллагууд хамрагдана/					
1	Төрийн байгууллагуудын дунд “Илүүдэл жингүй -Албан хаагчид” болзолт уралдаан	2022.03.21- 2023.03.21	Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс	Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Т.Хөвсгөл
2	Төрийн байгууллагын албан хаагчдын биеийн жингийн индексийг тодорхойлох		Эрүүл мэндийн газар	Биеийн тамир, спортын газар, Агентлаг, байгууллагууд	Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Т.Хөвсгөл
3	Болзлыг дүгнэж, үр дүнг тооцох	2023.03.10	Эрүүл мэндийн газар	Биеийн тамир, спортын газар, Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Г.Нарангэрэл
Зорилт-2. Нийтийн биеийн тамираар хичээллэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр байгууллага, сум, аж ахуйн нэгжүүд, биеийн тамирын багш, арга зүйчид, спортын холбоод, клубууд аяны хүрээнд тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх					

1.	Нийтийн биеийн тамирыг эрчимжүүлэх нь зөвлөгөөн, аяны нээлт зохион байгуулах	2022.04.08	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар	Дэлгэрмөрөн цогцолбор сургууль, Спортын холбоо, клубууд	Ажлын хэсэг
2	Агентлаг, байгууллага, сум, аж ахуйн нэгж, спортын холбоод, клубууд, арга зүйч, биеийн тамирын багш нар аяны хүрээнд тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	2022.04.01-05.01	Агентлаг, байгууллагууд	Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар	Биеийн тамир, спортын газрын Биеийн тамир, чийрэгжилтийн алба
Зорилт -3. Нийтийг хамарсан идэвхтэй дасгал хөдөлгөөн / өглөөний дасгал, алхах, гүйх, дугуй унах,/-ийг дэмжсэн олон талт арга хэмжээг зохион байгуулах, тогтмол дасгал хөдөлгөөн хийгдэх заал, талбай, барилга байгууламж нийтийн эзэмшлийн газар, цэцэрлэгт хүрээлэн, гадаа талбайг сурталчлан таниулах					
1	Дасгал хөдөлгөөн хийх спортын заал, гадаа талбай, цэцэрлэгт хүрээлэнг сурталчлан таниулах үйл ажиллагаа /мэдээлэл хийх телевизүүдэд хуваарь гаргах, аннос хэвлүүлэх, мэдээллийн самбар, боршур, зөвлөмжийг телевиз, цахим сүлжээгээр түгээх, групп чат нээх /	2022.03.21-04.21	Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллага, сайтууд	Биеийн тамир, спортын газрын арга зүйч Б.Батаа
2	6.30-7.30 хооронд өглөөний дасгал хөдөлгөөнийг хэвшүүлэх	2022.03.21-2023.03.21	Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар Хөгжимт драмын театр	Аймгийн Ерөнхий боловсролын суруулиуд, спортын холбоод, клубууд	Биеийн тамир, спортын газрын Биеийн тамир, чийрэгжилтийн алба, Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн багш Н.Мандахцэцэг
3	Мөрөн суманд “Чингүнжавын талбай”, “Биеийн тамир спортын газар”-ын гадаа талбай, “Соёмбо цогцолбор”-ын талбайд өглөөний дасгалыг хийж хэвшүүлэх	2022.05.01-10.01	Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар, Мөрөн сумын ЗДТГ, Хөгжимт драмын театр	Спортын холбоо, клубууд	БТСГ-ын Биеийн тамир, чийрэгжилтийн алба, Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Т.Хөвсгөл

4	Бүх нийтийн алхалт зохион байгуулах	2022.09 сард	Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар Гүйлт, алхалтын клуб	Агентлаг, байгуулллагууд, ТББ-ууд, иргэд	БТСГ-ын арга зүйч Г.Баярдэлгэр
5	Нийтийн биеийн тамирын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд “Идэвхтэй-Эрүүл амьдрал” өдөрлөг зохион байгуулах	2022.06 сард	Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар Спортын холбоо, клубууд	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Аймгийн ахмадын хороо,	БТСГ-ын Биеийн тамир, чийрэгжилтийн алба, ЭМГ-ын мэргэжилтэн Т.Хөвсгөл
6	Дугуйн аялалыг тогтмолжуулж, хичээллэгсэдийн тоог нэмэгдүүлэх	2022.05-10 сард	Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар, аймгийн Дугуйн холбоо	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс	БТСГ-ын дасгалжуулагч О.Баатармөнх
7	Нийтийн цэнгээнд бүжгийн тэмцээн зохион байгуулах	2022. 09 сард	Аймгийн Бүжгийн холбоо, Аялгуу, Баясахуй бүжгийн холбоо	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар	БТСГ-ын ахлах арга зүйч Б.Ганчимэг
8	Авто машингүй өдөр -10000 ахлам арга хэмжээ	2022.06 сард	Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс	БТСГ-ын ахлах арга зүйч Б.Ганчимэг, ЭМГ-ын мэргэжилтэн Т.Хөвсгөл
9	ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд “Гимнастрадаг хийж хэвшүүлье” уриалга гаргаж хэрэгжүүлэх	2022.04.15-2023.03.10	Боловсрол шинжлэх, ухааны газар	Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар, Ерөнхий боловсролын сургуулиуд	Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн Б.Төмөрчөдөр
10	Ахмадын төвүүдийн дунд “Дасгалаа хийж хэвшигчээ” хөдөлгөөн өрнүүлэх	2022.04.15-2023.03.10	Ахмадын холбоо	Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар	Мөрөн сумын Ахмадын хорооны дарга Т.Ганбаатар
11	Аяны хаалт, шагнал гардуулах арга хэмжээ	2023.04 сард	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар	Спортын холбоод, Ажлын хэсэг	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтийн мэргэжилтэн Г.Нарангэрэл, БТСГ-ын ахлах арга зүйч Б.Ганчимэг, ЭМГ-ын мэргэжилтэн Т.Хөвсгөл

Зорилт-4 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, холбоо, клуб, фитнесс төвүүдийн хамтын ажиллагааг уялдуулах					
1	Эрүүл зөв хооллолт лекц	2022.03-21- 2023.03.10	“Лидр леди”, “Гэрэлт од” клуб, Уламжлалт ангаах ухааны эмч П.Эрдэнэ-Очир	Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар	ЭМГ-ын мэргэжилтэн Т.Хөвсгөл
2	Спортын холбоод, ТББ-уудын уулзалт, арга хэмжээ зохион байгуулах	2022.05 сард	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар	Ажлын хэсэг	БТСГ-ын ахлах арга зүйч Б.Ганчимэг
3	Нэгдсэн тайлан, дүн мэдээг гаргаж, үр дүнг тооцож, хурлаар хэлэлцүүлэх, архивлах	2023.3 сард	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар	Ажлын хэсэг	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтийн мэргэжилтэн Г.Нарангэрэл, БТСГ-ын ахлах арга зүйч Б.Ганчимэг, ЭМГ-ын мэргэжилтэн Т.Хөвсгөл